



ХЭРЭГЛЭГЧИЙН ИТГЭЛИЙН ИНДЕКС

түүвэр судалгааны тайлан



Энэхүү түүвэр судалгаа нь
Санхүү, эдийн засгийн хямрал: Монгол Улс
судалгааны ажлын хүрээнд хийгдэв.



НЭЭЛТТЭЙ
НИЙГЭМ
ФОРУМ

Тайланг бэлтгэсэн: МУИС-ийн эдийн засгийн сургуулийн
Эдийн засгийн онолын тэнхимийн судлаачдын баг

Б.АЛТАНЦЭЦЭГ

Ахлах судлаач, АНУ-ын Виржиниагийн их сургуулийн докторант

Д.БАЯРМАА

МУИС-ийн ЭЗО-ын тэнхимийн багш, магистр

Б.СУВД


Судлаач, МУИС –ийн тэргүүлэх профессор, доктор (Ph)

Б. МӨНХСОЁЛ

Зөвлөж, хянан тохиолдуулсан Нээлттэй Нийгэм Форумын менежер

© Нээлттэй Нийгэм Форум
Нээлттэй Нийгэм Форумын санаачилга болон санхүүжилтээр
энэхүү тайланг бэлтгэв.

Хаяг: Жамъян гүний гудамж
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар -48,
Утас: 976-11-318207
Факс: 976-11-324857
Вэб: <http://www.forum.mn>
И-мэйл: osf@forum.mn



Оршил

Хэрэглэгчийн итгэлийн индекс 36.7 байгаа нь Улаанбаатар хотод хэрэглэгчийн итгэл муу байгааг харуулж байна. Ерөнхий индексийн утга ийм бага байгаа нь ялангуяа өнөөгийн байдалд хэрэглэгчид туйлын итгэл муутай (12.9) байгаатай холбоотой. Хэрэглэгчид ирэх зургаан сарын хугацаанд эдийн засгийн байдал дээрдэх боловч эдийн засгийн идэвх сул, уналттай хэвээр байна гэж үзэж байна. Ихэнх өрхүүд өнөөдөр удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжгүй үе гэж үзэж байна. Ирэх зургаан сарын хугацаанд нийт өрхийн багахан хэсэг буюу 16 хувь нь үл хөдлөх хөрөнгө, үүнд, 5 хувь нь орон сууц худалдаж авахаар төлөвлөж байна.

Дэлхийн эдийн засгийн хямралын нөлөө 2008 оны сүүлээс эхлэн Монголын эдийн засагт мэдрэгдэж эхлээд байна. Энэ нөхцөлд эдийн засгийн өнөөгийн байдал болон цаашдын хандлагын талаарх судалгаа шинжилгээ, ялангуяа, Монголчууд эдийн засгийн байдлыг хэрхэн үнэлж байгаа болон ойрын ирээдүйд ямар хулээлттэй байгаа талаарх мэдээ мэдээлэл туйлын ач холбогдолтой билээ. Иймээс Монголын өрхүүд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж буй болон эдийн засгийн ойрын төлвийн талаар хэрээрэг өөдрөг хулээлттэй байгааг тодорхойлох, түүнд дүн шинжилгээ хийх, олон нийтэд энэ талын мэдээлэл хүргэх зорилго тавьсан.

Эдийн засгийн нийт эрэлтийн хамгийн том бүрэлдэхүүн хэсэг нь хувийн хэрэглээний зардал байдаг. Монгол Улсад ч бүтээгдэхүүн үйлчилгээний зах зээлийн хамгийн том худалдан авагч нь Монголын нийт өрхүүд бөгөөд YCSX-ны мэдээлснээр 2008 онд өрхийн хэрэглээ ДНБ-ий 52 хувийг эзэлж байна. Хувь хүн, айл өрхүүд хэрэглээний зардал, хадгаламжаа төлөвлөхдөө орлого, ажил эрхлэлт, үнийн түвшин, хүү, банк санхүүгийн тогтвортой байдал зэрэг үзүүлэлтүүдийн өнөөгийн байдал болон эдгээр үзүүлэлтүүд ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх талаар өөрсдийн таамаглал, хулээлтэд үндэслэн шийдвэрээ гаргадаг. Жишээлбэл, орон сууц худалдаж авах эсэх тухай шийдвэр гаргахад



орон сууцны ирээдүйн үнийн талаарх таамаглал өнөөгийн үнийн нэг адил чухал нөлөөтэй. Өөр бусад хүчин зүйлс тогтмол үед, өрхүүд цаашдаа үнэ бурна гэж таамаглаж байвал орон сууц худалдаж авахаа хойшлуулах ба харин үнэ өснө гэж таамаглаж байвал худалдаж авах шийдвэр гаргана. Өрхийн энэхүү шийдвэр нь орон сууцны барилгын салбарын үйлдвэрлэгчдэд шууд нөлөөтэй юм. Эндээс үзвэл, Монголчууд ойрын ирээдүйд эдийн засаг хэрхэн өөрчлөгднө гэж хүлээж буйгаас манай бизнес, санхүүгийн байгууллагынхны үйл ажиллагаа шууд хамаарна. Тухайлбал, Монголын өрхүүд эдийн засгийн байдал тааруухан байна гэсэн хүлээлттэй байвал өрхийн зарлагаа бууруулахаар төлөвлөх ба өрхийн бүтээгдэхүүн, үйлчилгээний эрэлт буурах тухай энэхүү мэдээлэл нь пүүс, компаниудын хувьд үйлдвэрлэлээ өсгөхгүй байх, хөрөнгө оруулалтаа хойшлуулах болон нөөцөнд байгаа бүтээгдэхүүний борлуулалтад илүү анхаарах зэрэг шийдвэр гаргахад хүргэнэ. Иймд гадаад орнуудад төрийн болон хувийн бизнес санхүүгийн байгууллагууд хэрэглэгчийн хүлээлтийн индексийг машанхааралтай ажиглаж, бодлого, үйл ажиллагааны төлөвлөгөөндөө оруулж тооцдог байна. Хэрэглэгчийн итгэлийн индекс нь эдийн засгийн өнөөгийн байдал болон ойрын ирээдүйд эдийн засагт гарах өөрчлөлтийн төлвийг өрхүүд хэрхэн үнэлж (таамаглаж) байгааг харуулдаг бөгөөд “Хэрэглэгчийн итгэлийн индекс” болон түүнтэй төстэй индексүүдийг олон улс оронд тооцож гаргадаг. Энэ судалгаагаар Монгол улсын “Хэрэглэгчийн итгэлийн индекс”-ийг Улаанбаатар хотын бүх өрхүүдийг хамарсан санамсаргүй түүвэр судалгааны аргаар анх удаа тооцон гаргаж байгаа бөгөөд цаашид тогтмол хэрэглэх боломжийг нээж өгч байгаагаараа ач

холбогдолтой юм. Ялангуяа, ойрын ирээдүйд бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт хэрхэн өөрчлөгдхөх хандлагатай байгаа талаарх мэдээлэл нь эдийн засгийн байдал эгзэтэй байгаа энэ үед төрийн болон хувийн байгууллагуудад бодлого, үйл ажиллагаагаа төлөвлөхөд нэн хэрэгцээтэй байх болно.

Манай оронд MYXAYT жил бүр үүнтэй төстэй индексийг бизнес эрхлэгчдийн дунд явуулдаг түүвэр судалгаагаар тооцож гаргасан байна. Харин бидний энэ судалгаа нь, нэгдүгээрт, Улаанбаатар хотын нийт өрхүүдийг хамруулан санамсаргүй түүвэрлэлт хийснээр судалгааны үр дүн нь Улаанбаатар хотын нийт өрхийг (хэрэглэгчдийг) төлөөлж чадахаараа онцлогтой. Хоёрдугаарт, уг түүвэр судалгааг жилд 2 удаа 6 сарын интервалтай явуулснаар эдийн засгийн төлөв байдал асар хурдан өөрчлөгдж буй энэ үед хэрэглэгчийн итгэл хагас жилийн хугацаанд хэрхэн өөрчлөгдж буй талаар мэдээлэл өгөх боломжтой юм.

ХИИ -ийн судалгаа, тооцох аргачлал

Хэрэглэгчийн Итгэлийн Индексийг тооцох түүвэр судалгааг Улаанбаатар хотод хоёр шатат санамсаргүй түүврийн аргаар хийнэ. Эхний шатанд хороодыг хүн амынх нь тоотой пропорционалиар санамсаргүйгээр сонгох ба дараагийн шатанд сонгогдсон хороодоос өрхүүдийг санамсаргүйгээр сонгоно. 2007 оны 12-р сарын 31-ний байдлаар Улаанбаатар хотын албан ёсны байнгын оршин суугчдын тоо 1005093, нийт өрхийн тоо 234923 байна. Улаанбаатар хот нь 9 дүүрэг, 132 хорооноос бүрддэг. Нийслэлийн Баянзүрх, Сонгинохайрхан дүүргүүдэд хүн амын төвлөрөл харьцангуй өндөр,



харин захын дүүргүүд болох Налайх, Багануур, Багахангайд хүн амын төвлөрөл эрс бага буюу нийт өрхийн дөнгөж б хувийг эзэлж байна.

Түүврийн хэмжээ

Хэрэглэгчийн Итгэлийн Индекс үнэлэх түүвэр судалгааны түүврийн оновчтой хэмжээг дараах томъёогоор тодорхойлсон.

$$n = \left[\frac{z_{\alpha/2}^2 p(1-p)}{e^2} \right]$$

Энд: n-түүврийн хэмжээ, p- тухайн сонголт хийх хүн амын хувь, e- итгэх завсар, α - ач холбогдлын түвшин, z- критик утга. Түүврийн хэмжээг тодорхойлох параметрүүд болох ач холбогдлын зэрэг 5%, итгэх завсар 3.1% байхаар авч байна. Харин р-ийн талаар урьдчилан таамаглах боломжгүй тул 0.5 буюу түүврийн хэмжээхамгийн их байлгах утгыг нь сонгосон. Тооцооноос үзвэл түүврийн оновчтой хэмжээ нь 999 өрх байна. Гэвч түүврийн бус алдаа гарахаас сэргийлэх үүднээс түүврийн хэмжээг томруулж 1100 өрх байхаар тодорхойлж байна.

Хоёр шатат санамсаргүй түүвэр

Түүвэр судалгааны эхний шатанд Улаанбаатар хотын 120 хорооноос өрхийн тоотой нь пропорциональ магадлалтайгаар 40 хороог санамсаргүйгээр сонгож харин хоёрдугаар шатанд сонгогдсон хороо тус бүрээс 25 өрх санамсаргүйгээр сонгож,¹ сонгосон өрхүүдээс асуулга авах замаар мэдээлэл цуглууллаа.

Түүвэр судалгааны аргачлал, асуулга

Хэрэглэгчийн итгэлийн индексийг тооцохдоо улс орнууд хагас жил, жил, 5 жил хүртэлх хугацааг хамруулсан байдаг. Энэ удаагийн асуулганд бид нэгээс дээш жилийн хугацааг хамруулаагүй.

Улаанбаатар хотын “Хэрэглэгчийн Итгэлийн Индекс” тодорхойлох судалгааны асуулгад дараах хүрээг хамруулсан. Үүнд: Өрхүүд

- эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн дүгнэж буй байдал
- эдийн засгийн ойрын төлвийг хэрхэн үнэлж (таамаглаж) буй байдал
- ойрын ирээдүйн хэрэглээгээ хэрхэн төлөвлөж буй байдал зэрэг орно.

Түүвэр судалгааны асуулга нь эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх өрхийн үнэлгээ, ирээдүйд гарах өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт, ойрын ирээдүйн худалдан авалтын хандлага, б болон 12 сарын хугацаанд эдийн засгийн зарим үзүүлэлтүүдэд гарах өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт болон өрхийн тухай мэдээлэл гэсэн үндсэн 5 хэсгээс бүрдэж байна. Одоо эдгээр бүлэг асуултуудыг тус бүрд нь авч үзье.

А. Эдийн засгийн өнөөгийн байдлын талаарх өрхийн үнэлгээ

Энэ хэсгийн зорилго нь Монголчууд эдийн засгийн өнөөгийн байдлыг хэрхэн үнэлж дүгнэж байгааг гаргах бөгөөд уг хэсэг нь ажил эрхлэлт, бизнесийн нөхцөл, удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлтийн өнөөгийн байдалд өрхийн өгч буй үнэлгээ болон өрхийн санхүүгийн байдалд нэг жилийн хугацаанд гарсан өөрчлөлтийн талаарх нийт 4 асуултаас бүрдэнэ.

¹ Багануур, Багахангай, Налайх дүүргийн 12 хороог түүвэрлэлтэд хамруулаагүй. Эдгээр дүүргүүд нийлээд УБ хотын нийт өрхийн б хувийг эзэлдэг бөгөөд байршилын хувьд хотоос нилээд алслагдсан байдаг.

B. Ирээдүйд эдийн засагт гарах өөрчлөлтийн талаарх өрхийн хүлээлт

Энэ хэсэг нь Монголчууд бизнесийн нөхцөл, ажил эрхлэлт, орлогод ирэх зургаан сарын хугацаанд гарах өөрчлөлтийн талаар ямар хүлээлттэй байгааг үнэлэх зорилготой бөгөөд З дэд асуултаас бүрдэнэ.

А, В хэсгийн асуултууд, хариултын сонголтыг олон улсад хийгддэг хэрэглэгчийн итгэлийн (хүлээлтийн) талаарх түүвэр судалгаануудад өргөн хэрэглэгддэг стандарт асуултуудаас сонгон авсан². Тухайлбал, АНУ, Англи, Австрали, Япон, Украин, Хятад, Өмнөд Солонгос, Канад зэрэг олон улсад өдгөэр асуултуудыг хэрэглэн индексээ тооцдог.³ А хэсгийн эхний 2 асуулт болон В хэсгийн 3 асуултын мэдээлэл нийлээд ХИИ тооцоход ашиглагдана.

C. Ойрын ирээдүйн худалдан авалтын хандлага

Удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн болон аялал жуулчлал нь эрэлтийн мэдрэмж өндөртэй байдаг. Эдийн засгийн мөчлөгийн талаарх тогтсон баримтаас үзвэл өдгөэр бүтээгдэхүүний хэрэглээний зардал нь эдийн засгийн мөчлөгийн дагуу өөрчлөгддөг ба өөрчлөлтийн хэмжээ нь ДНБ-ий өөрчлөлтөөс хэд дахин их буюу далайц ихтэйбайдаг⁴. Жишээлбэл, эдийн засгийн уналтын

2 Өрхийн хэрэглээний шийдвэрт өрхийн байнгын буюу насан туршийн орлого нөлөөлдөг. Хэрвээ өрхийн байнгын орлого өсвөл тэд хэрэглээгээ нэмэгдүүлэх боломжтой, харин түр зуурын орлогын өсөлт нь хэрэглээнд төдийлэн нөлөөлөхгүй гэж үздэг. Байнгын орлого нь өнөөгийн болон ирээдүйн орлогоор тодорхойлогддог учраас энэ төрлийн судалгаануудад өнөөгийн болон ирээдүйн орлоготой холбоотой асуулгуудыг оруулдаг.

3 Conference Board, Michigan, Washington-ABC News Consumer Comfort Index MasterCard Worldwide index of consumer confidence

4 Mankiw, N.Gregory, 1982 "Hall's consumption hypothesis and durable goods", Journal of Monetary Economics 10, 417-425



үед өрхүүд юуны өмнө автомашин, цахилгаан бараа зэрэг удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний хэрэглээний зардлыг бууруулдаг.


Энэ хэсэгт бид өрхүүдээс ирэх зургаан сарын хугацаанд орон сууц, гэр, газар зэрэг үл хөдлөх хөрөнгө, автомашин, цахилгаан бараа болон аялал жуулчлалын үйлчилгээ худалдан авахаар төлөвлөж буй эсэх талаар мэдээлэл авах юм. Ингэснээр эхний судалгаагаар ойрын ирээдүйд Монголд удаан эдэлгээтэй бүтээгдэхүүний эрэлт ямар байх талаар мэдээлэлтэй болох ба дараагийн судалгаанаас эхлэн энэхүү эрэлтэд гарах өөрчлөлтийг үнэлэх боломжтой болно.

D. Эдийн засгийн гол гол үнийн түвшин ирэх зургаан болон 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх тухай өрхүүдийн хүлээлт

Дээр дурьдсанчлан өрхүүдийн хэрэглээ, хадгаламжийн талаарх шийдвэрт өнөөгийн үнийн түвшин төдийгүй, үнийн түвшин ирээдүйд хэрхэн өөрчлөгдөх таамаглал нэн чухал байдаг. Энэ хэсэгт бид ирэх хагас болон бүтэн жилийн хугацаанд инфляци, зээлийн хүү, төгрөгийн ханш, орон сууцны үнэ хэрхэн өөрчлөгдөх талаар өрхүүдийн таамаглалыг үнэлнэ. Ингэснээр хүлээгдэж буй инфляци, төгрөгийн ханшийг тооцох боломжтой. Олон улсад хийгдэж байгаа ижил төстэй судалгаануудаас үзэхэд ихэвчлэн өдгөэр үзүүлэлтүүд 12 сарын хугацаанд хэрхэн өөрчлөгдөх талаар асуусан байдаг, харин манай орны хувьд эдийн засгийн нөхцөл байдал ихээхэн хурдтай өөрчлөгдж байгаа учир асуулгад зургаан сарын хугацааг оруулсан.


E. Өрхийн тухай мэдээлэл

Өрхийн тэргүүний нас, өрхийн ам бүл, боловсрол зэрэг мэдээлэл нь түүвэр судалгааг эх олонлогтой



харьцуулж, түүнийг хэр зэрэг төлөөлж байгааг шалгах ач холбогдолтой. Түүнчлэн түүврийн тархалтад тодорхой хэмжээний гажилт байвал аль чиглэлд байгааг тодорхойлж, судалгааны үр дүнгийн шинжилгээнд оруулж тооцно. Өрхийн орлого, үл хөдлөх хөрөнгө, ажил эрхлэлтийн байдал зэрэг үзүүлэлтүүдэд үндэслэн Улаанбаатар хотын хэмжээнд орлого хуваарилалт, ядуурлын түвшин, ажилэрхлэлтийн байдлыг үнэлэхээс гадна эдгээр үзүүлэлтүүдтэй холбоотой судалгааны үр дүнг бусад судалгаатай харьцуулах боломж олгох юм. Түүнчлэн, өнөөгийн эдийн засгийн нөхцөл байдалд ажил эрхлэлт, ажилгүйдлийн талаарх мэдээлэл нэн чухал ба УБ хотын нийт өрхийг төлөөлөх түүвэр судалгаанаас эдгээр үзүүлэлтүүдийг үнэлж гаргах нь бодлого боловсруулагчдад ихээхэн ач холбогдолтой гэж үзсэн. Ажил эрхлэлтийн талаарх асуултууд нь Үндэснийстатистикийнхорооны ажилэрхлэлтийн байдал, ажилгүйдлийн шалтгааныг тодорхойлдог аргачлалд үндэслэсэн. Ажилгүйдлийн байдлыг тодорхойлох асуудлуутай холбоотойгоор YCX, НХХЯ-ны зарим мэргэжилтэнтэй зөвлөлдсөн болно.

Эхний түүвэр судалгаа нь дээр дурдсан үзүүлэлтүүдийн талаар анхны мэдээллийн санг бүрдүүлнэ. Харин түүнээс 6 сарын дараа хийгдэх түүвэр судалгаанаас эхлэн дээрх үзүүлэлтүүдийн өөрчлөлтийн хандлагыг харах, шинжилгээн хийх боломжтой болно.



ХИИ тооцох аргачлал

Нэгдүгээр хэсгийн эхний хоёр асуултад өгөх мэдээлэл нь ХИИ-ийг тооцоход болон түүний дэд индекс болох “Өнөөгийн байдлын индекс”-ийг тооцоход хэрэглэгдэнэ. Харин хоёрдугаархэсгийн З асуултад өгөх мэдээлэл нь ХИИ-ийг тооцоход болон түүний дэд индекс болох “Хүлээлтийн индекс”-ийг тооцоход ашиглагдана.

Түүвэр судалгааны үр дүн

Түүврийн алдаа

Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ) судалгааны түүврийн төлөөллийг шинжлэхдээ “Хүн ам, орон сууцны 2000 оны улсын тооллого: Улаанбаатар хотын тооллогын дүн”, “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008” түүвэр судалгаа зэрэг бусад судалгаатай өрхийн ам бүл, орон сууцны нөхцөл болон өрхийн тэргүүний талаарх зарим мэдээллийг харьцуулж үзсэн болно.

ХИИ түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүдийн орон сууцны нөхцөл, төрлөөрх тархалт нь ӨНЭЗС 2007-2008 судалгааны үр дүнтэй харьцангуй төстэй байна. Харин энэ хоёр судалгааны үр дүн 2000 оны хүн ам, орон сууцны тооллогоны дүнгээс нилээд ялгаатай байгаа нь 2000 оноос хойш Улаанбаатар хотын өрхийн орон сууцны нөхцөлөөрх тархалт ихээхэн өөрчлөгджээ гэсэн дүгнэлтэд хүргэж байна. Ялангуяа, орон сууцанд амьдардаг өрхийн эзлэх хувь буурсан нь УБ-руу шилжих хөдөлгөөн ихэссэнээс гэр, хашаа байшинд амьдардаг өрхийн тоо өссөнтэй холбоотой байж болох юм.



Хүснэгт 1. Орон сууцны төрөл

	ХИИ (Улаанбаатар)	Хүн ам, орон сууцны тоологоор (Улаанбаатар, 2000)	ӨНЭЗС 2007-2008 (Хот)
Гэр	21.9	21.8	28.8
Хашаа байшин	32.3	30	30.9
Орон сууц	35.8	44.8	39.8
Бусад	0.4	3.4	0.5
Нийт	100.0	100.0	100

2000 оны хүн ам, орон сууцны тоологоор нийслэл хотын нэг өрхөд дунджаар 4.7 хүн ногдож байжээ. Харин 2007 оны статистикийн эмхтгэлийн мэдээгээр Улаанбаатар хотын өрхийн дундаж ам булийн тоо 4.1 ба “Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа” (ӨНЭЗС)-ны 2007-2008 оны үр дүнгээр 3.9 байна. Үүнээс үзвэл ХИИ судалгааны өрхийн дундаж ам бул 4.05 байгаа нь эх олонлогийн дундажтай маш ойрхон байгаа юм. (Хүснэгт 2-г харна уу).

Хүснэгт 2. Өрхийн ам булийн тоо

	ХИИ (Улаанбаатар)	Хүн ам, орон сууцны тоологоор (Улаанбаатар, 2000)	ӨНЭЗС 2007-2008 (Хот)	2007 оны статистикийн эмхтгэл
Өрхийн ам булийн тоо	4.05	4.7	3.9	4.1

Түүнчлэн өрхийн ам булийн тоог орон сууцны төрлөөр тооцож үзэхэд, ХИИ судалгааны өрхүүдийн хувьд гэрт болон хашаа байшинд амьдардаг өрхийн дундаж ам бул хамгийн их буюу тус тус 4.3, 4.2 бөгөөд цаашид орон сууцны нөхцөл сайжрахын хирээр өрхийн дундаж ам булийн тоо буурч байна. ӨНЭЗС-ны дүнгээр хашаа байшинд амьдардаг өрхийн ам бул 4.2 буюу хамгийн их нь байжээ.

Хүснэгт 3. Өрхийн дундаж ам булийн тоо, орон сууцны төрлөөр

	ХИИ (Улаанбаатар)	ӨНЭЗС 2007-2008 (Хот)
Гэр	4.3	4
Хашаа байшин	4.2	4.2
Орон сууц	3.8	3.5
Бусад	3.9	3.4

Хэдийгээр бусад судалгаатай харьцуулах боломжгүй боловч өрхийн ам булийн тоо, орон сууцны төрлийг дүүргээр харах нь нэлээд сонирхолтой мэдээлэл өгч байна. Хан уул дүүрэгт гэрт амьдардаг өрхийн хувь, өрхийн дундаж ам булийн тоо бусад дүүрэгтэй харьцуулахад хамгийн өндөр боловч Улаанбаатар хотын нийт гэрт амьдардаг өрхөд тус дүүргийн өрхийн эзлэх хувь нь 15 буюу Баянзүрх, Сонгинохайрхантай харьцуулахад харьцангуй бага байна. Улаанбаатар хотын хэмжээгээр нийт гэрт амьдардаг өрхийн 30 орчим хувь нь Сонгинохайрхан дүүрэгт харьялгаж байна.



Хүснэгт 4. Өрхийн дундаж ам бүл, дүүргээр

	Нэг өрхөд ногдох хүний тоо	Орон сууцны төрөл		Нийт	
		Гэрт	Байшин	Гэрт	Байшин
Хан уул	4.56	44	56	15.1	5.4
Баянзүрх	3.84	26.3	73.7	21	16.5
Баянгол	3.93	12	88	8.2	16.9
Сүхбаатар	3.98	13.6	86.4	15.5	27.7
Чингэлтэй	3.87	16	84	11	16.1
Сонгинохайрхан	4.37	32	68	29.2	17.4
Нийт			100	100	

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Өрхийн тэргүүний насын бүлгээр өрхүүдийн эзлэх хувийг Хүснэгт 5-д харууллаа.

Хүснэгт 5. Өрхийн тэргүүний насын бүлгээр, хувь

	ХИИ (Улаанбаатар)	ӨНЭЗС 2007-2008 (Хот)
<30	12	11
30-39	23.6	28
40-49	32.9	31.3
50-59	19	16.4
60=<	12.5	13.4

Уб хотын нийт өрхийн гуравны нэг орчим нь 40-50 насын өрхийн тэргүүнтэй өрхүүд байна.

"Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа 2007-2008"-д өрхийн тэргүүний дундаж нас Улаанбаатар хотод 45.9 байсан бол ХИИ түүвэр судалгааны дүнгээр энэ нь 44.6 байна (Хүснэгт 6-аас харна уу).

2007-2008 оны ӨНЭЗС-ны дүнгээр эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрх нь улсын хэмжээнд нийт өрхийн 78.0 хувь, Улаанбаатарын хэмжээнд 71.7 хувийг эзэлж байжээ. Харин ХИИ түүвэр судалгаанд хамрагдсан нийт өрхийн 79.6 хувь нь эрэгтэй өрхийн тэргүүнтэй байхад 20.4 хувь нь эмэгтэй өрхийн тэргүүнтэй байна.

Хүснэгт 6. Өрхийн тэргүүний дундаж нас, хүйс

	ХИИ (Улаанбаатар)	ӨНЭЗС 2007-2008 (Улаанбаатар)
Өрхийн тэргүүний дундаж нас	44.55	45.9
Эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн хувь	79.6	71.7

Жич: ӨНЭЗС-аар 2002-2003 онд эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн хувь 76.6 байсан.

ХХИ-ийн түүвэр судалгааны дүнгээр Улаанбаатар хотод өрхийн тэргүүний боловсролын түвшин улсын дундажтай харьцуулахад нилээд өндөр байна (Хүснэгт 7).



Хүснэгт 7. Өрхийн тэргүүний боловсролын түвшин

	ХИИ (Улаанбаатар)	ӨНЭЭС 2007-2008 (Улсын дундаж)
Бага	2.8	15.8
Бүрэн бус дунд	9.9	23.1
Бүрэн дунд	32.6	31.4
Тусгай мэргэжлийн сургууль	11.8	13
Дээд, магистр	42.9	16.6

ХИИ түүвэр судалгаанд хамрагдсан өрхүүдийн шинж байдал, үндсэн үзүүлэлтүүд нь “Өрхийн нийгэм, эдийн засгийн судалгаа 2007-2008” болон “Хүн ам, орон сууцны тооллого 2000” судалгааны үр дүнтэй маш ойрхон бөгөөд бидний түүврийн үр дүн 96.9 хувийн найдвартай байгаа учраас ХИИ түүвэр судалгаа нь Улаанбаатар хотын өрхүүдийг төлөөлөх чадвартай гэж үзэж болно. Иймээс бидний судалгааны үр дүн нь судалгаанд хамрагдсан өрхүүдээр хязгаарлагдахгүйгээр Улаанбаатар хотын нийт өрхүүдийн хувьд яригдаж байна гэсэн үг юм.

Хэрэглэгчийн итгэлийн индекс (ХИИ)

Энэ хэсэгт, бид дээр дурьсан түүвэр судалгааны мэдээллийг ашиглан ҮБ хотын хэрэглэгчийн итгэлийн индексийг тооцоолж, шинжилгээ хийнэ.

ХИИ-ийг тооцох аргачлал

Хэрэглэгчийн итгэлийн индексийг тооцохдоо түүвэр судалгааны асуулгын өнөөгийн эдийн засгийн байдал, ажлын олдоц, ирээдүйн эдийн засгийн байдал, ирээдүйн ажлын байрны олдоц болон ирээдүйн өрхийн орлогын тухай 5 асуултад өгсөн мэдээллийг ашиглан тооцно. Эхлээд, эдгээр 5 үзүүлэлт тус бүрийн хувьд индекс тооцох ба тооцоонд зөвхөн “сайн”, “муу” гэсэн хариултуудыг л оруулна.

$$I_i = \frac{2G_i}{(G_i + B_i)} \cdot 100$$

Энд: I_i - асуулт i -ийн индекс, G_i - “сайн” гэж үнэлж буй өрхийн тоо, B_i - “муу” гэж үнэлж буй өрхийн тоо. Эндээс үзвэл “сайн”, “муу” гэж үнэлж буй хүмүүсийн тоо тэнцүү байвал I_i нь 100 байх ба энэ үед эдийн засгийн байдал хэвийн байна гэж үзнэ. Харин 100-аас бага байвал хэрэглэгчийн итгэл муу байна, 100-аас их байвал хэрэглэгчийн итгэл сайн байна гэж үзнэ. Жишээ нь, бүх хүн сайн гэж үнэлэхэд I_i хамгийн өндөр утга болох 200 хувь гэсэн утгаа авдаг. Харин бүх хүн муу гэж үнэлж байвал 0 гэсэн хамгийн бага утгаа авна. Ерөнхий ХИИ нь эдгээр 5 индексийн энгийн дундаж юм. ХИИ-ээс гадна, өнөөгийн эдийн засгийн байдалтай холбоотой 2 индексийн дундаж болох “өнөөгийн байдлын индекс” ба ойрын ирээдүйн эдийн засгийн байдалтай холбоотой 3 индексийн дундаж болох “ирээдүйн хүлээлтийн индекс”-ийг тооцно.⁵

Дээр дурьсанчлан ХИИ нь 0-ээс 200-ын хооронд утга авах ба 100-аас их бол итгэл сайн, бага

⁵ ХИИ-ийг зарим байгууллагууд тодорхой нэг оны индекстэй харьцуулж тооцдог. Тухайлбал, АНУ-ын Conference Board гэдэг байгууллага асуулт тус бүрийн индексийг 1985 онтой харьцуулдаг ба үүний үндэслэлийг 1985 онд эдийн засаг хэвийн (хэт халаагүй, унаагүй) байсан гэдгээр тайлбарладаг.

бол итгэл муу байна гэж үздэг. Дээр дурьдсан аргаар тооцсон ХИИ-ийг хүснэгт 8-д харуулж байна. УБ хотын ХХИ 36.7 буюу 100-аас эрс бага байгаагаас үзвэл хэрэглэгчийн итгэл тааруухан байна. Түүнчлэн өрхүүд эдийн засгийн өнөөгийн байдлыг (өнөөгийн байдлын индекс 12.9) их муу байна гэж үнэлж байгаа бөгөөд б сарын дараа ч эдийн засгийн байдал тааруухан (ирээдүйн хүлээлтийн индекс 52.6) хэвээрээ байна гэсэн хүлээлттэй байгаа боловч одоогийнхоос нилээд дээр болно гэж үзэж байна.

Хүснэгт 8. Хэрэглэгчийн Итгэлийн Индекс

	Орон Боловсрол ¹ сууцны нөхцөл				
	Нийт	Дээд	Дооруур	Логотохород	Орон суурин
Хэрэглэгчийн Итгэлийн Индекс	36.7	40.6	34.0	36.9	36.6
Өнөөгийн байдлын индекс	12.9	16.6	9.9	10.4	17.4
Хүлээлтийн индекс	52.6	56.6	50.1	54.5	49.3

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009


Манай оронд ХИИ-ийг Монголбанкны мөнгөний бодлого, судалгааны газар МУИС-ийн Социологийн тэнхимтэй хамтран 2002, 2003 онуудад, Сантмарал сангаас 2007 онд үнэлсэн. Гэвч эдгээр судалгаа нь асуулга, аргачлалын хувьд энэхүү түүвэр судалгаанаас нилээд зөрүүтэй тул ХИИ-ийг шууд харьцуулах боломжгүй юм.



Хэрэглэгчдийн итгэл тодорхой булгүүдийн хувьд ялгаатай байгаа эсэх нь ихээхэн сонирхолтой юм. Хүснэгт 8-д боловсрол, орон сууцны нөхцлөөр ялгаатай өрхүүдийн ХИИ-ийг харуулж байна. Дээд боловсролтой өрхүүд эдийн засгийн байдлыг доогуур боловсролтой өрхүүдээс арай өөдрөгөөр үнэлж байна. Тухайлбал, дээд боловсролтой өрхүүдийн хувьд ХИИ 40.6 байхад доогуур боловсролтой өрхүүдийнх 34 байна. Орон сууцны нөхцлөөр нь авч үзвэл ерөнхий ХИИ адилхан 37 орчим хувь байна. Гэр болон хашаа байшинд амьдардаг өрхүүд орон сууцанд амьдардаг өрхүүдийг бодвол өнөөгийн байдлыг арай доогуур ирээдүйг арай өөдрөгөөр үнэлж байна.

Түүвэр судалгааны дүнгээс үзвэл нийт өрхийн 5.7 хувь нь тэдний санхүүгийн байдал нэг жилийн өмнөхөөс сайжирсан гэж үзэж байхад 53.9 хувь нь муудсан гэж үзэж байна. Түүнчлэн өнөөдөр удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжтой үе гэж 25 хувь нь үзэж байхад 57 хувь нь тохиромжгүй үе гэж үзэж байна.

Зураг 1. Яг одоо удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжтой үе мөн үү?





Өрхүүд эдийн засгийн гол гол үнэ ойрын ирээдүйд хэрхэн өөрчлөгднө гэж үзэж буй нь ихээхэн сонирхолтой билээ. ХИИ-ийн түүвэр судалгаанаас үзэхэд эдийн засгийн гол гол үнүүдэд хагас жил, жилийн хугацаанд гарах өөрчлөлтийн талаар УБ хотын өрхүүд дараах бодлотой байна. Нийт өрхийн 50 хувь нь ирэх 6 сарын хугацаанд инфляци дунджаар 10-15

хувиар өснө гэж үзэж байхад 18 хүрэхгүй хувь нь үнийн түвшин 10-аас 15 хувиар буурна гэж үзэж байна. Түүнчлэн ирэх 6 сарын хугацаанд америк долларын ханш өсч дунджаар 1600-1700 төгрөг болно гэж 30.5 хувь нь үзэж байгаа бол 28 хувь нь долларын ханш буурч дунджаар 1250-1300 төгрөг болно таамаглаж байна.

Хүснэгт 9. Хүлээлт

Хариулт	Инфляци		Ам. долларын ханш		Зээлийн хүү		Орон сууцны үнэ
	6 сарын хугацаанд	1 жилийн хугацаанд	6 сарын хугацаанд	1 жилийн хугацаанд	1 жилийн хугацаанд	1 жилийн хугацаанд	
Өснө	49.2	42.6	30.5	25.9	31.7	21.4	
Өөрчлөгдөхгүй	17.7	15.5	19.0	19.0	25.5	20.2	
Буурна	14.3	13.4	28.0	20.4	21.0	48.9	
Мэдэхгүй	18.8	28.5	22.5	34.7	21.8	9.5	

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Нийт өрхийн 31.7 хувь нь зээлийн хүү ирэх нэг жилийн хугацаанд өснө, харин 21 хувь нь буурна гэж үзсэн байна. Харин орон сууцны үнэ ирэх нэг жилийн хугацаанд буурна гэж нийт өрхийн бараг тал нь үзэж байхад өснө гэж 20 гаруй хувь нь л үзэж байна.

Өрхийн зарлага

Энэ хэсэгт ирэх зургаан сарын хугацаанд өрхүүд машин, цахилгаан бараа, аялал жуулчлал зэрэг эрэлтийн мэдрэмж өндөртэй бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авахаар төлөвлөж буй эсэхийг шинжилнэ. УБ хотын нийт өрхийн 16.1 хувь нь ямар нэгэн үл хөдлөх хөрөнгө авахаар төлөвлөж байгаа бөгөөд 5.4 хувь нь орон


сууц, 5 хувь нь хашаа байшин худалдаж авах төлөвлөгөөтэй байна.

Хүснэгт 10. Төлөвлөж буй худалдан авалт

Хариулт	Үл хөдлөх хөрөнгө	Томоохон эд хогшил	Аялал, жуулчлал	Автомашин
Тийм	16.1	34.7	37.7	16.7
Үгүй	83.9	65.3	62.3	83.3

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Томоохон эд хогшил, цахилгаан барааны худалдан авалтын эрэлт нийт өрхийн 34.7 хувь, үүнд хөргөгч, угаалгын машин, компьютерын



эрэлт нийлээд хамгийн их буюу 24.5 хувь байна.

Нийт өрхийн гуравны нэгээс илүү нь ямар нэг байдлаар аялал жуулчлал хийнэ гэж хариулсан. Тухайлбал, 11.7 хувь нь дотоодын амралт, сувилалд амрах төлөвлөгөөтэй байгаа бол 21.9 хувь нь хөдөө хамаатан садныдаа амрахаар төлөвлөж байна.

Автомашин худалдан авна гэсэн өрх 16.7 хувь ба үүнээс тал орчим хувь нь Монголд яваагүй хуучин машин авахаар төлөвлөж байна. Өрхийн шинж байдлаас нь харвал 40 хүртэлх насын өрхийн тэргүүнтэй өрх нийт автомашин худалдан авалтын 47.9 хувийг хийхээр байна. Автомашин худалдан авах, томоохон эд хогшил болон цахилгаан барааны эрэлт нь өрхийн тэргүүний настай хамааралтай байхад үл хөдлөх хөрөнгийн эрэлт нь настай хамааралгүй байна.

Аялахаар төлөвлөж буй өрхүүдийн хувьд ихэнх нь өрхийн тэргүүний боловсролын түвшин өндөр бөгөөд үл хөдлөх хөрөнгө эзэмшиж байна.

Нийт өрхийн 80.8 хувь нь үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг бөгөөд 42.5 хувь нь хашаа байшин, 27.6 хувь нь орон сууц, 27 хувь нь газар, 7.7 зуслангийн байр тус тус эзэмшдэг байна. Харин үнэт цаас, хувьцаа эзэмшдэг өрх хамгийн цөөн буюу ердөө 4.8 хувь байна.

Банкны секторт итгэх итгэл

ҮБ хотын нийт өрхүүдийн 57.8 хувь нь мөнгөн хөрөнгөө банкинд байршуулахыг зүйтэй гэж үзэж байгаа бөгөөд үүнээс 43.2 хувь нь төгрөгөөр байршуулахыг илүүд үзжээ. Харин нийт өрхийн нилээд буюу дөрөвний нэг орчим нь гэртээ хадгалах нь зүйтэй гэж үзсэн байна.

Хүснэгт 11. Мөнгөн хөрөнгийн байршил

Банкинд хадгалахаар Гэртээ хадгалахаар Биет хөрөнгө боловно Бусад	Хувь	57.8	23.8	16.2	2.4

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009


Банкинд итгэх итгэл нь өрхийн тэргүүний боловсролын түвшин, өрхийн нэг хүнд ногдох орлогоос ээрэг хамааралтай байна.

Өрхийн орлого, ажил эрхлэлт

Эдийн засгийн өсөлт удааширч буй өнөө үед өрхийн орлого, ажил эрхлэлтийн байдал ямар байгаа талаарх мэдээлэл нь бодлого боловсруулагчид, судлаачдад нэн сонирхолтой, чухал мэдээлэл билээ. Иймд түүвэр судалгааны асуулгад энэ талаар цөөн тооны асуултууд оруулсан. Зураг 2-т ҮБ хотын өрхийн сарын дундаж орлогын тархалтыг харуулж байна. ҮБ хотод өрхийн дундаж орлого 300.0-400.0 мянган төгрөг байна.



Зураг 2. Өрхийн сарын дундаж орлогын тархалт



Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Харин орон сууцны нөхцлөөр нь авч үзвэл гэр хороолол болон орон сууцанд амьдардаг өрхийн дунд орлогын асар ялгаатай байдал ажиглагдаж байна. Тухайлбал, гэр болон хашаа байшинд амьдардаг өрхийн дундаж орлого 200.0-300.0 мянган төгрөг байгаа нь орон сууцанд амьдардаг өрхийн дундаж орлогоос 200.0 мянган төгрөгөөр бага байна.

Ядуурал

Өрхийн нэг хүнд ногдох орлогын өгөгдлийг ашиглан ядуурлын түвшинг тооцоход, Улаанбаатар хотод ядуурлын түвшин 57.5⁶ байна. Түүнчлэн нэн ядуурлыг тооцож үзэхэд 11.5% байна. Ядуурлын түвшин ҮБ хотод их өндөр гарсан нь өнгөрсөн оны сүүлээр эхэлсэн эдийн засгийн бууралттай холбоотой ядуурал эрс өссөн байж болзошгүй гэж дүгнэхэд хүргэж байна. Дараах хүснэгтэд ядуурлын түвшинг тодорхой бүлгүүдээр харуулсан байна. Ядуурлын түвшин боловсролын түвшин болон орон сууцны нөхцлөөр туйлын ялгаатай байна. Тухайлбал,

дээд боловсролтой өрхүүдийн 34 хувь нь ядуу байхад, дээдээс доогуур боловсролтой дөрвөн өрх тутмаас гурав нь ядуу байна. Гэр, хашаа байшинд амьдардаг өрхийн 75 хувь нь ядуу байхад орон сууцанд амьдардаг өрхүүдийн 30 орчим хувь нь ядуу байна.

Хүснэгт 12. Ядуурлын түвшин (хувиар)

Ядуурлын түвшин	
Улаанбаатар	57.5
Улаанбаатар хотын ядуу өрхийн тоо	135081
Өрхийн тэргүүний хүйс	
Эм	61.8
Эр	56.4
Боловсролын түвшин	
Дээд	34.1
Доогуур	75
Байрны нөхцөл	
Орон сууц, хувийн байшин	29.8
Гэр хороолол	74.7

6 Ядуурлын түвшин өрхийн нэг хүнд ногдох сарын дундаж орлого нь амьжиргааны доод түвшин болох 94000 төгрөгнөөс доогуур байгаа өрхийн нийт өрхөд эзлэх хувиар тооцлоо



Мөн өрхийн тэргүүн нь төрийн харьяаллын байгууллагад ажилладаг өрхийн дунд ядуурлын түвшин 44.8 байгаа нь хувийн байгууллагад ажилладаг өрхөөс 8.9 хувиар өндөр байна.

Нийт өрхийн 80.8 хувь нь ямар нэгэн үл хөдлөх хөрөнгө эзэмшдэг ба 4.8 хувь нь бонд эзэмшдэг гэж хариулсан байна. Нийт өрхийн 28 хувь нь орон сууц, 43 хувь нь хашаа байшин, 27 хувь нь газар, 15 хувь нь гэр эзэмшиж байна.

Ажилгүйдэл

Одоо ажилгүйдлийн түвшинг авч үзье. Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин 10.0 хувь байна. Орон сууцны нөхцлөөр нь авч үзвэл, гэр, хашаа байшинд амьдардаг өрхийн ажилгүйдлийн түвшин орон сууцанд амьдардаг өрхийнхөөс 2 дахин өндөр байна. Түүнчлэн эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин 11.5 байгаа нь эрэгтэйчүүдийнхээс 2.9 хувиар өндөр байна.

Хүснэгт 13. Ажилгүйдлийн түвшин

Ажилгүйдлийн түвшин	
Улаанбаатар	10.0
Хүйс	
Эм	11.5
Эр	8.6
Байрны нөхцөл	
Орон сууц, хувийн байшин	5.8
Гэр хороолол	12.7

Дүгнэлт

Энэхүү судалгаанаас тооцсон, Хэрэглэгчийн итгэлийн индекс 36.7 байгаа нь Улаанбаатар хотод хэрэглэгчийн итгэл муу байгааг харуулж байна. Ерөнхий индексийн утга ийм бага байгаа нь ялангуяа өнөөгийн байдалд хэрэглэгчид туйлын итгэл мутай (12.9) байгаатай холбоотой. Хэрэглэгчид ирэх зургаан сарын хугацаанд эдийн засгийн байдал дээрдэх боловч эдийн засгийн идэвх сул, уналттай хэвээр байна гэж үзэж байна. Ихэнх өрхүүд өнөөдөр удаан эдэлгээтэй бүтээгдэхүүн худалдаж авахад тохиромжгүй үе гэж үзэж байна. Ирэх зургаан сарын хугацаанд нийт өрхийн багахан хэсэг буюу 16 хувь нь үл хөдлөх хөрөнгө, үүнд, 5 хувь нь орон сууц худалдаж авахаар төлөвлөж байна. Үүгээр зогсохгүй, орон сууцны үнэ бурна гэж үзэж буй өрхийн тоо өснө гэж үзэж байгаа өрхийн тооноос 2 дахинаас их байна.

Улаанбаатар хотод ядуурлын түвшин 57.5 байгаа нь бусад судалгаатай харьцуулахад ихээхэн өндөр байна. Тухайлбал, 2008 оны "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа"-гаар УБ хотын ядуурлын түвшин 21.9 хувь байна. Гэвч бид өмнөх судалгааны үр дүнтэй ХИИ-ийн түүвэр судалгааны үр дүнг дараах шалтгаануудын улмаас шууд жиших боломжгүй юм. Нэгд, ХИИ-ийн түүвэр судалгаа явуулах үеийн эдийн засгийн орчин, "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа" хийгдсэн үеийн эдийн засгийн орчноос эрс ялгаатай юм. ХИИ-ийн түүвэр судалгаа нь эдийн засгийн үйл ажиллагаа ихээхэн суларсан үед хийгдсэн бол "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгаа" нь 2008 он буюу эдийн засгийн үйл ажиллагаа эрчимтэй буюу хэт халалттай байх үед хийгдсэн. Хоёрт, ХИИ-ийн түүвэр судалгаа



нь өрхийн орлогын мэдээлэлд үндэслэсэн. Ийм тохиолдолд, өрх орлогоо санаатай болон санамсаргүйгээр дутуу мэдээлэх эрсдэл байдаг. Тухайлбал, орлогоо зориуд багасгаж хэлэх эсвэл мөнгөн бус хэлбэрээр орж ирдэг орлогоо оруулж тооцоогүйгээс дутуу мэдээлэх явдал тохиолддог. Түүвэр судалгааны мэдээллийг ашиглан шалгахад зориуд багасгасан тохиолдол маш ховор байгаа юм. Уг судалгаанаас харагдаж буй нэг сонирхолтой үр дүн нь орон сууц болон гэр хороололд амьдардаг өрхүүдийн орлого, амьжиргааны түвшин эрс ялгаатай байгаа явдал юм.

Улаанбаатар хотод ажилгүйдлийн түвшин 10.0 байгаа нь их өндөр үзүүлэлт юм. Орон сууцны нөхцлөөр ажилгүйдлийн түвшинг ялгаж үзэхэд мөн л ядуурлын нэгэн адил эрс тэс ялгаатай байна. Тухайлбал, гэр хороололд ажилгүйдлийн түвшин орон сууцныхаас 2 дахинаас илүү байна.

Түүнчлэн хүйсийн ялгаатай байдал их байгаа нь ядуурал, ажилгүйдэл, орлогын үзүүлэлтээс харагдаж байна. Тухайлбал, эмэгтэйчүүдийн дунд ажилгүйдлийн түвшин эрэгтэйчүүдийнхээс бараг 3 хувиар өндөр байна. Түүнчлэн эмэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийн ядуурлын түвшин эрэгтэй өрхийн тэргүүнтэй өрхийнхөөс 6 хувиар өндөр байна.

Бодлогын зөвлөмж

- Хэрэглэгчийн эдийн засагт итгэх итгэл муу байгаа энэ үед тэдний итгэлийг сайжруулахын тулд нийгэм, эдийн засгийн өнөөгийн байдал, цаашдын хандлага болон эдийн засгийг дэмжихэд чиглэсэн төрийн бодлогын талаар олон нийтэд тодорхой, шуурхай мэдээлэх шаардлагатай.
- Түүнчлэн ойрын хугацаанд бүтээгдэхүүн, үйлчилгээний нийт эрэлт бага хэвээр байх хандлагатай байгаа энэ үед төр өөрийн зарлагаараа дамжуулан нийт эрэлтийг урамшуулах боломжтой.
- Хэрэглэгчийн итгэл муу, эдийн засгийн зогсонги байдал цаашид үргэлжилнэ гэж таамаглаж, хүлээж байгаа үед сангийн бодлогоор дамжуулан урамшуулах бодлого явуулах боломжтой.
- Хэрэглэгчийн итгэлийн индекс судалгаагаар гарсан үзүүлэлт, үрдүнгнийгмийнхаламжийн тогтолцоог боловсронгуй болгох, төрийн зарлагын үр ашгийг дээшлүүлэхэд ашиглах боломжтой
- Гэр хороололд амьдарч байгаа өрхүүд орон сууцанд байгаа өрхүүдээс эрс доогуур амьжиргаатай (ажилгүйдэл өндөр, ядуурал их, амьдрах орчин нөхцөл муу, боловсрол доогуур г.м.) байгааданхаарч түүнд нөлөөлж буй хүчин зүйлийг судалж, амьжиргааг нь дээшлүүлэхэд чиглэсэн бодлого хэрэгжүүлэх шаардлагатай байна.



АШИГЛАСАН МАТЕРИАЛ

ConferenceBoard, 2000 "Consumer Confidence Survey"

Richard Gabay, 2004 "Survey results: Uncertainty rises in June", The Conference Board of Canada

International Center for Policy Studies, "Consumer Moods in Ukraine, 2009"

Sydney C. Livingston "Consumer Confidence and consumer spending", The Journal of Economic Perspectives, Vol.18, No 2, pp 29-50

Jeff Dominitz, Charles F. Manski "How should we measure consumer confidence?" The Journal of Economic Perspectives, Vol.18, No 2, pp 51-66

ҮСГ, 2000 он "Хүн ам орон сууцны тооллого"

ҮСГ, 2004 он "Ажиллах хүчний судалгааны үндсэн тайлан"

Сант марал, 2009 "Банкны салбарын судалгаа"

ҮСГ, 2009 он "Өрхийн нийгэм эдийн засгийн судалгааны 2007-2008 оны үр дүнгийн үндсэн хүснэгтүүд", урьдчилсан тайлан

Монгол банк, Мөнгөний бодлогын газар, 2005 "Монгол улсын нийгэм эдийн засгийн

өнөөгийн байдал, банк санхүүгийн байгууллагын үйл ажиллагааны талаарх түүвэр судалгаа-2005", Монгол банк

Friedman, Milton, 1957 "A Theory of the consumption function" Princeton University Press

Mankiw, N. Gregory, 1982 "Hall's consumption hypothesis and durable goods", Journal of Monetary Economics 10, 417-425

Romer, Christina D. 1986 "Spurious Volatility in Historical Unemployment Data", Journal of Political Economy 94, pp1-37

<http://www.conference-board.org/economics/ConsumerConfidence.cfm>

www.investopedia.com/terms/m/mcsi.asp

<http://www.washingtonpost.com/wp-srv/business/articles/consumerindexdata.htm>

<http://www.masterintelligence.com/ViewRegionReport.jsp?hidReportTypeId=2&hidRegionId=1&hidUserId=null>

http://www.xinhuafinance.com/en/charts/indicator/ccci/ccci0809_en.jpg

ХАВСРАЛТ

Хавсралт 1. Үл хөдлөх болон санхүүгийн хөрөнгө

	Үл хөдлөх хөрөнгө эзэмшилэг эсэх	Үнэт цаас, хувьцаа эзэмшилэг эсэх
Тийм	80.8	4.8
Үгүй	19.2	95.2

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Хавсралт 2. Үл хөдлөх хөрөнгийн төрөл (нийт өрхөд эзлэх хувь)

	Орон сууц	Хашаа байшин	Газар	Гэр	Зуслангийн байр
Хувь	27.6	42.5	27	14.5	7.7

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Хавсралт 3. Ажиллах хүч

Хөдөлмөрийн насын хүмүүст эзлэх хувь	
Хүйс	
Әм	53.2
Әр	46.8
Сүүлийн 7 хоног ажил эрхэлсэн эсэх	
Тийм	47.4
Үгүй	52.6

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Хавсралт 4. Ажил эрхлэлт /салбараар/

Ажил эрхэлж буй хүмүүст эзлэх хувь	
Ажилладаг салбар	
ХЭАА, нөхөрлөл, хоршоолол	4.9
Хувьцаат компани	14.5
ХХК	20.2
Улсын үйлдвэрийн газар	2.5
Төрийн, төсөөт байгууллага	26.3
Төрийн бус байгууллага	5.0
Хувиараа хөдөлмөр эрхлэгч	26.6

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Хавсралт 5. Ажил эрхлэлтийн байдал

	Ажил эрхлэлтийн байдал Хүмүүст зэлж буйд
Гэрээгээр ажиллагч	60.5
Ажил олгогч	5.6
Хувиараа ажиллагч	25.5
Хоршооллын гишүүн	1.5
Гэр бүлийн бизнест цалин авалгүй оролцогч	2.0
Бусад	4.9

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

Хавсралт 6. Ажил эрхлээгүй байгаа шалтгаан

Ажил эрхлээгүй хүмүүст зэлж буйв	
Сургуульд сурдаг	40.4
Тэтгэвэр, нөхөн олговорт	16.8
Өвчтэй, тахир дутуугийн группт	6.3
Гэрийн ажилтай	11.3
Тохирох ажил олдохгүй байгаа	8.9
Ажил хайж байгаа	10
Бусад	6.3

Эх үүсвэр: ХИИ-ийн түүвэр судалгаа, 2009

1. Өрхийн тэргүүний боловсрол дипломын болон түүнээс дээш бол өрхүүд “дээд” гэсэн ангилалд үгүй бол “доогуур” гэсэн ангилалд орно.